



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/39

Даланзадгад

Магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн, чиг үүргийг батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1, 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/503 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг I хавсралтаар, зөвлөлийн гүйцэтгэх үүргийг II хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс /Ж,Отгонбайгал/, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв /Я.Болдбаатар/, Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн /Т.Оюундүү/ нарт тус тус даалгасугай.

3. Тав хүртэлх насны хүүхдийн эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх журам, тушаалыг мөрдөж, дотоодын хяналт үнэлгээ, сургалт сурталчилгааг үе шаттай зохион байгуулж ажиллахыг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2016 оны А/50 дугаар тушаалын 0-5 насны хүүхдийн эндэгдлийн заалтууд, 2017 оны А/04 дүгээр тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА




Ц.ӨНӨРЖАРГАЛ

C:\ Desktop\2020 on TUSHAAL

461200106

Эрүүл мэндийн газрын даргын  
2020 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн  
А/39 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



**МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:**

Зөвлөлийн дарга : Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга


Гишүүд:

- Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга, хүүхдийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга, статистикч эмч
- Эмнэлгийн тусламжийн чанар асуудал хариуцсан мэргэжилтэн
- Анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Шим билэг өрхийн эрүүл мэндийн төвийн хүүхдийн эмч
- Бусад эмч, мэргэжилтэн /шаардлагатай тохиолдолд/

Нарийн бичгийн дарга:

- Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн /хүүхдийн эндэгдэл хэлэлцэх үед/
- Эх барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн /эрт нярайн эндэгдэл, амьгүй төрөлт хэлэлцэх үед/

Эрүүл мэндийн газрын даргын  
2020 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн  
А/39 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



**МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ  
ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРЭГ**

1. Зөвлөлийн дарга нь эндэгдлийн хурлыг зохион байгуулах, бэлтгэл ажил, шийдвэр, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
2. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь эндэгдэлтэй холбоотой материалыг статистикч эмчээс хүлээн авч, материалтай урьдчилан танилцаж, магадлан хэлэлцэх хуралд танилцуулах, хурлын товыг зөвлөлийн даргатай тохирох;
3. Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь хурлын зар хүргэх, хурал зохион байгуулах өрөө тасалгааг зохицуулах, хурлын протоколыг хөтөлж, магадлан хэлэлцсэн дүгнэлт, материалыг албан бичгээр холбогдох байгууллагад хүргүүлэх;
4. Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга, статистикч эмч нь хүүхдийн эндэгдлийн мэдээ, анхан шатны бичиг баримтыг хүлээн авч үнэн зөв, бодит байдлыг хянаж, хүүхдийн ерөнхий мэргэжилтэнд хүлээлгэн өгч, хурал дууссаны дараа хүлээн авч тухайн байгууллагад хүргүүлэх;
5. Эмнэлгийн тусламжийн чанар асуудал хариуцсан мэргэжилтэн нь тусламж үйлчилгээний эрсдэлийг үнэлэх, алдаанаас суралцах, дахин давтахаас сэргийлэх талаар санал оруулах мэдээлэл бэлтгэх;
6. Гишүүд нь хариуцсан ажлын чиглэлээр үнэлэлт дүгнэлт өгч цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмжид санал өгөх, өмнөх хурлын шийдвэрийг биелүүлэх, хэрэгжилтийг хангаж тайлагнаж ажиллах;
7. Зөвлөл нь эрүүл мэндийн сайдын 2019 оны А/503 тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллах;
8. Хүүхэд эндсэнээс хойш 1 сарын дотор багтаан магадлан хэлэлцэх хурлыг хийж дүгнэлтийг гаргах бөгөөд эндэгдэл гараагүй улиралд төлөвлөгөө, зөвлөмжийн хэрэгжилтийг хэлэлцэх;
9. Зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийг байгууллагын удирдлагад танилцуулан төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг зохион байгуулах